



**НИЙСЛЭЛИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ
ДАРГЫН БОЛОН ДЭД ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2014 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 4/113

Улаанбаатар

Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн
ахлах шийдвэр гүйцэтгэгч болон шийдвэр гүйцэтгэгч нарт

Улсын ерөнхий гүйцэтгэгчийн 2014 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн ажил эрчимжүүлэхээр өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.3.2-д заасныг удирдлага болгон ДААЛГАХ НЬ::

Нэг.Шийдвэр гүйцэтгэгч нарт

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/224 дугаар тушаал, 2014 оны 01/511 тоот албан бичиг, Улсын ерөнхий гүйцэтгэгчийн өгсөн үүрэг, чиглэл, Албаны даргын 2014 оны А/17 дугаар тушаалын биелэлт бүрийг хангахаар "Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэл хяналтын системийн аюулгүй ажиллагааны журамд"-д заасны дагуу ажиллагаатай болон түдгэлзүүлсэн нийт хувийн хэргийн баяжилтыг 2014 оны 05 дугаар сарын 27-ны дотор цахим бүртгэлийн системд бүрэн оруулсан байх,
2. Ажиллагаатай болон түдгэлзүүлсэн гүйцэтгэлийн хувийн хэрэг бүрт жигд хүрч, гүйцэтгэх баримт бичигт явуулах 20 хоногийн хугацаатай ажлын төлөвлөгөө гарган ахлах шийдвэр гүйцэтгэгчээр хянуулж, батлуулан уг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг бодитой явуулж, үр дүн гаргах,
3. Өдөр тутам 5-аас доошгүй төлбөр төлөгчийн хаягаар биечлэн очиж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг 9 цагаас 16 цагийн хооронд явуулж, явуулсан ажиллагаагаа цахим бүртгэлд оруулан, ахлах шийдвэр гүйцэтгэгчид ажлаа тайлагнах,
4. Гүйцэтгэлийн бодит биелэлтийг улсын дундажаас бууруулахгүй, 7 хоногт 2-оос доошгүй материал хаах, сарын хугацаанд барьж ажиллах тогтсон хувиа бууруулахгүй ажиллах,
5. Өргөдөл гомдол байнга гаргадаг болон шүүхийн шатанд маргаантай гүйцэтгэх баримт бичигт онцгой анхаарч, хуулийн хугацаанд тайлбар нотлох баримтыг хүргүүлэн, явуулсан ажиллагаагаа хамгаалан шүүх хуралдаанд

тогтоосон цагаас хоцролгүй очиж Ахлах шийдвэр гүйцэтгэгчийн хамт оролцох, түүнчлэн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон, сэргээх үндэслэл бий болсон үед төлбөр төлөгчийн эд хөрөнгө, бусад эрхэд тавьсан хоригийг цаг алдалгүй сэргээж, бусдын хууль ёсны эрх ашиг сонирхолыг хөндөгдөхөөс хамгаалан ажиллах, өргөдөл гомдол гаргагчид өргөдлийн хариуг биечлэн эсхүл баталгаат шуудангаар хүргүүлэх,

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2013 оны А/79 дугаар тушаалаар батлагдсан “Гар утас болон үүрэн телефоны дугаар ашиглах” журмыг чанд баримтлан мөрдөх, ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэхдээ дүрэмт хувцсыг тогтмол өмсөж хэвших,

Хоёр.Ахлах шийдвэр гүйцэтгэгч нарт

1. Цахим бүртгэлд баяжилт оруулсан байдалд өдөр тутам хяналт тавьж ажиллах, үүрэг даалгавар биелүүлээгүй шийдвэр гүйцэтгэгчийн талаарх саналаа Албаны даргын зөвлөлийн хуралдаанаар оруулан, хэлэлцүүлэх

2. Ажил эрчимжүүлэх 20 хоногийн хугацаатай ажлын төлөвлөгөөг батлан, биелэлтэнд өдөр тутам хяналт тавин ажиллах,

3. Шийдвэр гүйцэтгэгчийг өдөр тутам 5-аас доошгүй төлбөр төлөгчийн хаягаар биечлэн очиж шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах нөхцлөөр хангаж, лавлагаа тараах ажлыг зохион байгуулалтын хэлбэрт оруулж, явуулсан ажиллагааг цахим бүртгэлд оруулсан байдлаар өдрийн ажлын мэдээг авч, үнэн зөв, бодитой мэдээ гаргах,

4. Гүйцэтгэлийн бодит биелэлтийг улсын дундажаас бууруулахгүй ажиллахад ажлаа зөв зохион байгуулж, 7 хоногт 2 материал хаагаагүй шийдвэр гүйцэтгэгчид зардлыг олгохдоо анхаарч, дараагийн долоо хоногийн даваа гарагийн өглөөний шуурхайд танилцуулах,

5. Өргөдөл гомдол байнга гаргадаг болон шүүхийн шатанд маргаантай буй гүйцэтгэлд түүнчлэн шүүх хуралдаанд шийдвэр гүйцэтгэгчийн хамт оролцох, өргөдөл гомдол гаргагчид өргөдлийн хариу биечлэн эсхүл баталгаат шуудангаар хүргүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллах,

6. “Гар утас болон үүрэн телефоны дугаар ашиглах” журмыг чанд баримтлан мөрдөх, ажлын байранд дүрэмт хувцас өмсөөгүй шийдвэр гүйцэтгэгчийн албан тоот бичгийг хянаж, гарын үсэг зурж баталгаажуулахгүй байх,

Энэ даалгаврын биелэлтийг ханган, нэгтгэж 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулахыг Ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахмад Н.Уранчимэг, ахмад Д.Анхтуяа, ахлах дэслэгч Д.Лхагвасүрэн нарт үүрэг болгов.

ДЭД ДАРГА, ХОШУУЧ



Ж.НАНДИНТУУЛ